



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/179

Мөрөн сум

Дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 20 дугаар тогтоолоор баталсан жижиг дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журмын 3.2, 3.2.2 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүдэд:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

-Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл

-Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, орон нутгийн өмч, жижиг, дунд үйлдвэрлэл, хоршооны бодлого үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн

2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгийн даргад даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН